



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/БСЧ

Улаанбаатар хот

“Оёдолчдын ур чадварын тэмцээн”-д
оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргээс 2024 оныг “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан 2024 оны 04 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд Налайх дүүрэгт зохион байгуулагдах Налайх, Багануур, Багахангай дүүргийн “Оёдолчдын ур чадварын тэмцээн”-д дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бэлтгэн оролцуулсугай.

2.Тэмцээнд оролцох жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн нэрсийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмцээнд оролцох оёдлын чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчдийн оролцоог ханган ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв (М.Өсөхдэлгэр)-д үүрэг болгосугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 1,216,600 (Нэг сая хоёр зуун арван зургаан мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга (Д.Хүрэлбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

гийн Багахангай дүүргийн
оны 07 сарын 11-ны өдөр
захирамжийн хоёрд

ОЁДОЛЧДЫН УР ЧАДВАРЫН ТЭМЦЭЭНД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Даавуу	м	30	20000	600,000
2	Даавуу (доторх)	м	30	15000	450,000
3	Бензин	л	70	2380	166,600
Нийт					1,216,600